



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 243,997,685.78 (хоёр зуун дөчин гурван сая есөн зуун ерэн долоон мянга зургаан зуун наян таван төгрөг далан найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, 229,271,324.83 (хоёр зуун хорин есөн сая хоёр зуун далан нэгэн мянга гурван зуун хорин дөрвөн төгрөг наян гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 1 дүгээр хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт тус тус балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 200,000,000.00 (хоёр зуун сая) төгрөгийн балансын үнэ бүхий 2 дугаар хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

3.Цагдаагийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 407,300,000.00 (дөрвөн зуун долоон сая гурван зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий 3 дугаар хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

4.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, бригадын генерал Ц.Амгаланбаяр, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа С.Баатаржав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

4.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

4.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

4.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

5. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 2 дүгээр сарын 24-ны өдрийн
21 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР,
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Нэгжийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээд
1	Лексус LX470, 05-56 УНЗ	2007/01/01	159,243,750.00	1	159,243,750.00	159,243,750.00	-	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
	Дүн				159,243,750.00	159,243,750.00	-	
1	Хьюндай соната, 50-56 УБЗ	2014/10/23	52,490,000.00	1	52,490,000.00	37,763,639.05	14,726,360.95	Цагдаагийн ерөнхий газар
2	Хьюндай элентра, 08-15 УНУ	2008/01/01	32,263,935.78	1	32,263,935.78	32,263,935.78	-	
	Дүн				84,753,935.78	70,027,574.83	14,726,360.95	
	Нийт дүн				243,997,685.78 (хоёр зуун дөчин гурван сая есөн зуун ерэн долоон мянга зургаан зуун наян таван төгрөг далан найман мөнгө)	229,271,324.83 (хоёр зуун хорин есөн сая хоёр зуун далан нэгэн мянга гурван зуун хорин дөрвөн төгрөг наян гурван мөнгө)	14,726,360.95 (арван дөрвөн сая долоон зуун хорин зургаан мянга гурван зуун жаран төгрөг ерэн таван мөнгө)	

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 24 дүгээр сарын 24 ны өдрийн
24 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМАНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Нэгжийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуриутлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ниссан патрол Y-62, 01-35 УНУ	2017/01/01	200,000,000.00	1	200,000,000.00	-	200,000,000.00
	Нийт дүн				200,000,000.00 (хоёр зуун сая төгрөг)		200,000,000.00 (хоёр зуун сая төгрөг)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 01 дүгээр сарын 24 ны өдрийн
24 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМАНД
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Нэгжийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Тоёота ландкрузер L200 VXR	2018/12/31	248,500,000.00	1	248,500,000.00	-	248,500,000.00
2	Хьюндай соната, 08-88 УБЗ	2018/12/31	79,400,000.00	1	79,400,000.00	-	79,400,000.00
3	Хьюндай соната, 04-90 УНУ	2018/12/31	79,400,000.00	1	79,400,000.00	-	79,400,000.00
	Нийт дүн				407,300,000.00 (дөрвөн зуун долоон сая гурван зуун мянган төгрөг)		407,300,000.00 (дөрвөн зуун долоон сая гурван зуун мянган төгрөг)